



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 03/35

Баан-Өндөр сум

Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн
2024 оны дүн батлах тухай

Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн 2024 оны жилийн эцсийн дүнг нийт 786,592,958,226.00 (долоон зуун наян зургаан тэрбум таван зуун ерэн хоёр сая есөн зуун тавин найман мянга хоёр зуун хорин зургаа) төгрөгөөр хавсралтаар баталсугай.

2.Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХБАТ

Албан хэрэгцээнд
6125010079

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
Ээлжит бус V хуралдааны 03/35 дугаар
тогтоолын хавсралт



**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН**

№	Хөрөнгийн ангилал	Хөрөнгийн дүн
1	Газар	34,943,550,600.00
2	Барилга, Байгууламж, Нийтийн эзэмшил	337,160,697,292.0
3	Машин, тоног төхөөрөмж	82,079,419,265.00
4	Тээврийн хэрэгсэл	26,850,758,234.00
5	Тавилга	16,002,411,466.00
6	Дуусаагүй барилга	148,006,928,539.00
7	Биет бус хөрөнгө	8,702,419,867.00
8	Түүх соёлын дурсгалт зүйлс	704,024,700.00
9	Бусад үндсэн хөрөнгө	132,142,748,264.00
	Нийт дүн	786,592,958,226.00

-000-

Албан хэрэгцээнд